



Г шүүтис - БУХС-г Г

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ  
ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ**

17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
11 дүгээр хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 252, 253  
E-mail: info\_seb@mul.s.edu.mn,  
Вэб сайт: www.mul.s.edu.mn

2026.04.14 № 01/24

Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Г

Эрдэм шинжилгээний бага  
хуралд оролцохыг урих тухай

Монгол Улсын гавьяат багш, Доктор (Ph.D), Профессор Л.Жаргалын нэрэмжит “Монгол улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд таныг оролцохыг урьж байна.


Хурлын үйл ажиллагаанд боловсрол, төрийн байгууллага, банк, санхүү, бизнесийн байгууллага зэрэг олон салбарын төлөөлөл оролцож санал бодлоо солилцоно.

Тус хурлаар төрийн санхүүгийн асуудал, төр хувийн хэвшлийн түншлэл, эдийн засаг, бизнесийн харилцаанд өгөгдлийн шинжилгээг ашиглах, загварчлах боломж, хиймэл оюун, машин сургалт, квант тооцоолол зэргийн үзүүлэх нөлөөлөл, тогтвортой хөгжил, ногоон эдийн засаг, тогтвортой санхүү, тайлагнал, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч буй арга хэмжээний үр нөлөө зэрэг асуудлуудыг хэлэлцэж санал зөвлөмж гаргах болно.

Хурал 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 09:00 цагт ХААИС-ийн Эдийн засаг бизнесийн сургуулийн Эрдмийн зөвлөлийн танхимд зохион байгуулагдана.

Хавсралт  хуудастай. ЭШБХ-ын удирдамжийг хавсаргав.

ЗАХИРАЛ



Т.ЭРДЭНЭЧУЛУУН

Захирлын 2026 оны 0.7 дугаар сарын 0.8 ний  
өдрийн 4/66 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ, ДОКТОР, ПРОФЕССОР Л.ЖАРГАЛЫН НЭРЭМЖИТ  
“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,  
ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

#### Нэг. Зорилго:

Энэхүү эрдэм шинжилгээний бага хурлын зорилго нь: Монгол улсын эдийн засаг, санхүүгийн орчны өнөөгийн байдлыг тодорхойлж хөгжих боломж, бодит шийдлийг илрүүлэх, шинэ санаа инновацыг дэмжих, судалгааны ажлыг олон нийтэд түгээхэд оршино.


#### Хоёр. Хамрах хүрээ

- 2.1. Эрдэм шинжилгээний хуралд эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж буй багш, судлаачид оролцоно.
- 2.2. Эрдэм шинжилгээний бага хурал нь бизнесийн удирдлага, менежмент, маркетинг, оновчлол, инновац, нягтлан бодох бүртгэл, аудит, татвар, санхүү, хүний нөөц болон эдийн засаг, статистикийн холбогдолтой дараах ерөнхий хүрээг хамарна.
  - 2.2.1. Төрийн санхүүгийн асуудлууд, төр ба хувийн хэвшлийн түншлэл
  - 2.2.2. Эдийн засаг, бизнесийн харилцаанд өгөгдлийн шинжилгээг ашиглах, загварчлах боломж
  - 2.2.3. Эдийн засаг, бизнесийн орчинд хиймэл оюун (AI), их өгөгдөл (Big data), машин сургалт (ML), квант тооцоолол (Quantum computing) зэрэг түйвээгч технологийн (Disruptive technology) үзүүлэх нөлөөлөл, сорилт, боломж, хэтийн хандлага.
  - 2.2.4. Технологи, инновац, байгальд орчинд ээлтэй эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа
  - 2.2.5. Тогтвортой хөгжил, ногоон эдийн засаг, ногоон санхүү, тогтвортой санхүү, тогтвортой тайлагнал зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч буй арга хэмжээний үр дүн, үр нөлөө, хэмжих арга зүй.
  - 2.2.6. Эдийн засаг, бизнес, санхүүгийн өнөөгийн байдлыг олон улсын байдалтай харьцуулах, авсан арга хэмжээний үр дүн, үр нөлөө, цаашдын хандлага
  - 2.2.7. Аж үйлдвэрийн IV хувьсгалын үр нөлөө, цаашдын чиг хандлагын хүрээнд эдийн засаг, бизнес, санхүүгийн харилцаанд гарч буй өөрчлөлт

#### Гурав. Илтгэлд тавигдах шаардлага

- 3.1. Эрдэм шинжилгээний илтгэлийн агуулгад тавигдах ерөнхий шаардлага:
  - 3.1.1. Эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлийн асуудлыг хамарсан, шинэлэг санаа, арга аргачлал дэвшүүлсэн байх;
  - 3.1.2. Шинжлэх ухааны тодорхой онол, судалгааны арга, аргачлал ашигласан, арга зүйн үндэслэлтэй байх;
  - 3.1.3. Бодит тоон болон тоон бус мэдээлэл ашигласан, мэдээллийн эх сурвалжийг баталгаажуулсан байх;
  - 3.1.4. Судалгааны ажилд дэвшүүлсэн санаа оновчтой, бодит амьдралд хэрэгжих боломжтой, тодорхой үр дүнд хүрсэн байх.
- 3.2. Эрдэм шинжилгээний илтгэлийн бүтэц, тавигдах шаардлага
  - 3.2.1. Гарчиг (илтгэлийн сэдэв, илтгэгч болон бусад судлаачийн нэр, байгууллага гэх мэт)
  - 3.2.2. Товч хураангуй (эрдэм шинжилгээний ажлын зорилго, ашигласан арга зүй, хүрсэн үр дүн гэх мэт)

- 3.2.3 Судалгааны үндсэн үр дүн, хэлэлцүүлэг (судалгааны ажилд ашигласан мэдээлэл, боловсруулалт, судалгаанд ашигласан арга загварын үр дүн, хэлэлцүүлэг)
- 3.2.4 Дүгнэлт, санал (судалгааны ажлын үр дүнтэй уялдсан хэрэгжүүлэх зөвлөмж, санал, анхаарах асуудлыг онцолсон байх)
- 3.2.5 Эх сурвалж, ашигласан материал



#### **Дөрөв. Хурлын зохион байгуулалт**

- 4.1. Хуралд хэлэлцүүлэх илтгэлүүдээр ЭШБХ-ын хураангуй хэвлүүлэх бөгөөд хураангуйг (\*.doc файл) бэлтгэж, 2026 оны 05 дугаар сарын 01-ны өдөр хүртэл [batkhuyag.m@mul.s.edu.mn](mailto:batkhuyag.m@mul.s.edu.mn) хаягаар хүлээн авна.
- 4.2. Эрдэм шинжилгээний бага хурлын хэлэлцүүлэг нь дараах хоёр үе шаттай явагдана.
- 4.2.1. Зохион байгуулагчдын хэлэлцүүлэг – Ирүүлсэн эрдэм шинжилгээний илтгэл нь хурлын зорилго, хамрах хүрээ, тавигдах шаардлагад нийцэж буй эсэхэд зохион байгуулагчдын зүгээс үнэлгээ өгч эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.
- 4.2.2. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн хэлэлцүүлэг – Энэ шатанд судлаачид эрдэм шинжилгээний бүтээлээ танилцуулах бөгөөд ЭЗБС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүд, судлаачдаас бүрдсэн шүүгчдийн баг үнэлгээ өгч илтгэлүүдийг байр эзлүүлнэ.
- 4.3. Эрдэм шинжилгээний бага хурлын хэлэлцүүлэг нь 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 09.00 цагаас, ХААИС-ийн ЭЗБС-ийн 301 тоотод зохион байгуулна.

#### **Тав. Хурлын үр дүн, урамшуулал**

- Эрдэм шинжилгээний хурлын үр дүнд хэвлэмэл эмхэтгэл (Proceeding) гаргана.
- Оролцсон илтгэлээс эхний 3 байр шалгаруулна.

1-р байр: Өргөмжлөл, мөнгөн шагнал /1'000'000 төгрөг/

2-р байр: Өргөмжлөл, мөнгөн шагнал / 700'000 төгрөг/

3-р байр: Өргөмжлөл, мөнгөн шагнал / 500'000 төгрөг/

#### **Зургаа. Зохион байгуулагч**

Зохион байгуулагч: ХААИС-ийн ЭЗБС-ийн Санхүүгийн тэнхим

Холбоо барих хаяг: ХААИС-ийн ЭЗБС-ийн Санхүүгийн тэнхим, 101 тоот

Утас: 99166115, 80819365

И-мэйл: [enkhtuya.a@mul.s.edu.mn](mailto:enkhtuya.a@mul.s.edu.mn)